

АВТОМАШИН ТҮРЭЭСЛЭХ ГЭРЭЭ

20 ... оны ... дугаар
сарын ...-ний өдөр

№

Улаанбаатар хот

Автомашин Түрээслэх гэрээ \ цаашид “гэрээ” гэх \-г нэг талаас:
\ТХГЭрчилгээ АЯ №, Улсын дугаар\-ийг төлөөлж Монгол Улсын иргэн
.....\цаашид “Түрээслүүлэгч” гэх\ иргэний үнэмлэх №, Регистр №..... ,
нөгөө талаас:ХХК- \цаашид “түрээслэгч” гэх\-ийг төлөөлж нар автомашин түрээслэхээр
Монгол Улсын Иргэний хуулийг иш үндэслэл болгон байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Түрээслүүлэгч нь улсын дугаартай, онд үйлдвэрлэгдсэн маркын суудлын автомашиныг ХХК-д.....төгрөгөөр түрээслүүлэх, түрээслэгч нь дээрхи автомашиныг түрээслэн авч ашиглах, шатахуун болон засвар, үйлчилгээ, сэлбэгийн зардлыг төлөх үүргийн харилцааг энэхүү гэрээгээр зохицуулна. Түрээсийн автомашиныг зөвхөн ажлын зориулалтаар ашиглана.
- 1.2. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 1.3. Гэрээний хугацаа нь уг автомашиныг түрээслэх гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш нэг жилийн хугацаатайгаар байгуулав. Гэрээний хугацаа дуусахаас өмнө аль нэг тал нь цуцлах санал тавиагүй, түрээсийн үйл ажиллагаа үргэлжилсээр байгаа бол мөн хугацаагаар сунгагдсанд тооцно.

ХОЁР. ТҮРЭЭСЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 2.1. Түрээсийн автомашин нь ажил үүрэг гүйцэтгэх бололцоотой, ажиллах таатай нөхцлөөр хангагдсан байна.
- 2.2. Түрээсийн төлбөрийг тохирсон хугацаандаа төлөхийг шаардах, Арбитрт нэхэмжлэл гаргах, түрээслэгч гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа сануулсаар атал биелүүлэхгүй бол гэрээг нэг талын санаачилгаар цуцлах
- 2.3. Гэрээний шатахуун болон засвар, үйлчилгээ, сэлбэгийн зардлыг тухай бүр нэхэмжлэх баримтыг үндэслэн өгч байхаар тохиров.

ГУРАВ. ТҮРЭЭСЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1. Түрээсийн автомашиныг ариг гамтай, эвдрэл гэмтэл учруулахгүй, зориулалтын дагуу ашиглах.
- 3.2. Түрээсийн төлбөр шатахуун болон бусад засварын зардлыг түрээслэгч тал хариуцна.
- 3.3. Түрээсийн автомашиныг гэрээний хугацаанд бусдад давхар түрээслэх, худалдах, бэлэглэх зэргээр захиран зарцуулахгүй байна.
- 3.4. Тухайн автомашиныг түрээслүүлэгчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулан түрээслэхгүй

ДӨРӨВ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 4.1. Байгалийн гэнэтийн гамшиг, ард иргэдийн бослого тэмцэл, барилга нурах гэх мэт талуудаас үл хамаарах нөхцөл байдлын улмаас тухайн автомашиныг үргэлжлүүлэн ашиглах боломжгүй болсон тохиолдолд талууд бие биеийн өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.

/Үргэлжлэл бий /